Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлого / сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого 4016454.9 мянган төгрөгөөр 1 хувиар тооцож 40164.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 137734.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 57820.7 мянган төгрөг болж, 79913.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ОНХС	1744.0	13808.6	12064.6	79.2
СХС	11620.4	1736.7	-9883.7	14.9
Төрийн сан	124370.0	42275.4	-82094.6	34.0
Дүн	137734.4	57820.7	-79913.7	41.9

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 57820.7 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 331752.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 325606.0 мянган төгрөг болж, 646.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №.2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ажиллагчидтай холбогдсон авлага	11671.1	1151.4	-10519.7
Байгууллагаас авах авлага	9999.5	7615.5	-2384
Хувь хүмүүсээс авах авлага	60303.1	52803,0	-7500.1
Зээлийн хүүгийн авлага	248773.5	260856.8	12083.3
Төлбөрт үйлчилгээний авлага	604.5		-604.5
татаас санхүүжилтын авлага	401.1	3179.3	
Дүн	331752.8	325606	-6146.8

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 146698.8 мянган төгрөгийн дараах авлага байна.

Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 248773.5 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 55850.0 мянган төгрөгийн зээл олгож, 46109.3 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 260856.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангаас 2017-2019 онуудад олгосон 11 иргэний 179,6 мянган төгрөгийн зээлийн авлага нь хэвийн төлөгдөж, 2011-2019 онуудад олгосон 18 иргэнтэй холбогдох 88494.5 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Хашааны авлага : 2014 онд сумын Засаг даргын захирамжаар жишиг хороололд айл өрхүүдэд сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх зээлийн гэрээгээр 10000.0 мянган төгрөгийн жигд хашаа барьж айл өрхүүдэд хүлээлгэн өгсөн байна.

Тайлант оны санхүүгийн тайланд хашааны авлага 9474.3 мянган төгрөгөөс 3270.0 мянган төгрөгийн авлага барагдаж эцсийн үлдэгдэл 6204.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажлын хүрээнд шүүхийн байгууллагад хандсан боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр аймгийн эвлэрүүлэн жуулчлах газарт хандахыг зөвлөсөн байна.

Эвлэрүүлэн жуулчлах газартай хамтран 2020.12.25 хүртэл төлбөр тооцоотой иргэдтэй төлбөр барагдуулах гэрээ хийсэн байна.

Малжуулахын авлага: Сумын ОНХС-аас 60000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар малжуулсан 5 багийн 13 өрх айлын гэрээний хугацаа дуусаж, 2020 онд 9 айл өрхөд 38000.0 мянган төгрөгийн 486 толгой мал шилжүүлэн олгож, 4 айл өрхийн 14000.0 мянган төгрөгийн малыг ууланд очих боломжгүй гэсэн шалтгааны улмаас шилжүүлээгүй байна.

Тайлант онд ОНХС-ийн дансанд 2 иргэнээс 7500.0 мянган төгрөгийн малын үнэ төвлөрүүлснийг оны эцэст татан төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Хүүхдийн цэцэрлэг нь ажилчдад тараан олгосон махны үнийг суутган тооцоогүй, тайлан балансад авлагаар бүртгээгүй 2728.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Эхний үлдэгдэл 161935.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 203971.1 мянган төгрөг болж, 42036.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт № 3. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	1632.3	5347.8	3715.5
Эм боох материал	6875.8	9203.8	2328.0
Бичиг хэргийн материал	8852.3	13885	5032.7
Аж ахуйн материал	101464.6	134204	32739.4
Сэлбэг хэрэгсэл	0	0	0.0
Түлш, шатах тослох материал	7299	7987.5	688.5
Барилгын засварын материал	455.0	995.5	540.5
Хүнсний материал	24140	22131.5	-2008.5
Бусад хангамжийн материал	10216	10216	0.0
Мал амьтад	1000		-1000.0
Дүн	161935.0	203971.1	42036.1

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЕБС –ийн бараа материалын дансны үлдэгдэл 110645.3 мянган төгрөг болж 23749.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд дээд шатны байгууллагаас тусгай зориулалтын бараа материал нийлүүлсэнтэй холбоотой байна.

Хүүхдийн цэцэрлэгийн бараа материалын дансны үлдэгдэл 30264.1 мянган төгрөг болж 5352.5 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд аж ахуйн материал, хүнсний материал нөөцөлсөнтэй холбоотой байна

Эрүүл мэндийн төвийн бараа материалын дансны үлдэгдэл 42900.6 мянган төгрөг болж 10500.3 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй 6705.7 мянган төгрөгийн эм боох материал шилжин ирсэн, тайлант онд ковид-19 үеийн бэлэн байдалд 3794.6 мянган төгрөгөөр бараа материал авч нөөцөлсөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь тайлант хугацааны бараа материалын тайланг нярав Цэнд-Аюуш ажлын байрны тодорхойлолтод заасан байгууллагын эд хогшил үндсэн ба эрээлтийн хөрөнгөд зохих журмын дагуу бүртгэл хөтлөн, хадгалалт хамгаалалтад хяналт тавих үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлж бараа материалын тайлан гаргаагүй зөрчил дутагдал илэрлээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 5152925.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6853081.9 мянган төгрөг болж, 1700156.9 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт № 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3693248.0	4933879.1	1240631.1
Тээврийн хэрэгсэл	195417	175426.7	-19990.3
Машин тоног төхөөрөмж	422706.4	455799.1	33092.7
Тавилга эд хогшил	267391.5	333663.2	66271.7
Түүх соёлын дурсгалт зүйл	64823.1	370638.1	305815
Дуусаагүй барилга байгууламж		69930.0	69930
Номын фонд	59712.3	64118.9	4406.6

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад үндсэн хөрөнгө	6595.7	6595.8	0.1
Программ хангамж	5645.0	5645.0	0
Бусад биет бус хөрөнгө	437386.0	437386.0	0
Дүн	5,152,925.00	6853081.9	1700156.9

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 0.0 мянган төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 61853.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 1682947.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн, бусад шилжүүлсэн 19669.0 мянган төгрөг, алталсан 64313.9 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансаар аймгийн ОХНС-ийн хөрөнгө оруулалтаар Шаргуугийн услалтын системийн толгойн барилгын ажил нь дуусаагүй байгаа тул 69930.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 15231.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 8764.2 мянган төгрөг болж, 6467.6 мянган төгрөгөөр буурсан байна.~~

Хүснэгт №.5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				
Ажилчидтай холбогдсон өглөг	12910.1	4257.6	-8652.5	-2
Хувь хүнд төлөх өглөг	351.7	382.2	30.5	-1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	922.0	225.0	-697.0	-1
Байгууллагад төлөх өглөг	1048.0	3899.4	2851.4	61
Нийт дүн	15230.8	8764.2	-6467.6	36

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 8764.2 мянган төгрөгийн өр байна. Өндөр дүнтэй өглөгийг сумын ЕБС-нь байгууллагад болон ажилчдад төлөх 5305.0 мянган төгрөгийн өр эзэлж байгаа бөгөөд бусад бага дүнтэй өглөгүүд дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4637921.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6092171.0 мянган төгрөг болж, 1451249.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 31. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2465163	2465163	0
Хуримтлагдсан үр дүн	431137.7	1886063.4	1454925.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1740944.6	1740944.6	0
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	676		-676
Дүн	4,637,921.30	6,092,171.00	1,454,249.70

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 1886063.4 мянган төгрөг болж 1454925.7 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар бий болсон, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүйгээр хүлээн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд 676.0 мянган төгрөгөөр буурсан нь ХОА-2021/ 3 /СТА-ТТЗ

үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал илүү бүртгэсэнтэй холбоотой өмнөх үеийн дүн дансанд залруулга хийгдсэн байна.

3.5.10 Орлогын данс

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 1210233.8 мянган төгрөгийн орлого өссөн нь татварын орлого 21416.0 мянган төгрөгөөр давж биелсэн, 291973.0 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт буурсан, 1184415.1 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэн, нэмэлт санхүүжилтийн орлого 438.8 мянган төгрөгөөр буурсан ба үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 4402.7 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой болно.

Аудитын илрүүлэлт:

- ЕБС нь байгууллагын туслах үйл ажиллагааны орлого болох үүрэн холбооны компаниудтай хийсэн түрээсийн гэрээний орлогыг өөрийн орлогын батлагдсан төлөвлөгөөнөөс давж биелсэн 3179.3 мянган төгрөгийн орлогыг нэмэлт дансанд байршуулсан.

3.5.11 Зардлын данс

Нийт зардал өмнөх оноос 406644.4 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 233822.9 мянган төгрөг буюу 15 хувиар өссөн, тогтмол зардал 4212.5 мянган төгрөг буюу 2 хувиар буурсан, хангамж бараа материалын зардал 4307.8 мянган төгрөг буюу 1 хувиар өссөн, нормативд зардал 28942.1 мянган төгрөг буюу 76 хувиар буурсан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 11229.0 мянган төгрөг буюу 16 хувиар буурсан, эд хогшил, урсгал засварын зардал 8130.0 мянган төгрөг буюу 42 хувиар буурсан, томилолтын зардал 5319.1 мянган төгрөг буюу 70 хувиар буурсан, бараа үйлчилгээний бусад зардал 69567.8 мянган төгрөг буюу 162 хувиар өссөн, урсгал шилжүүлэг 9099.6 мянган төгрөг буюу 40 хувиар буурсан байна.

Зардлын данстай холбоотой батлагдсан төсвийг зориулалт бус, анхан шатны баримтын бүрдэл дутуу зардлыг санхүүжүүлсэн зөрчил дутагдал илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ЕБС нь хүүхдийн хоолны хүнсний зардлаас бага үнэтэй түргэн элэгдэх хөрөнгө бэлтгэсэн
- Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв нь тайлант онд бараа материалын худалдан авалтыг "И" баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байгаа зэрэг зөрчил илэрсэн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Буянт сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 38 дугаар тогтоолд Буянт сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 48326.8 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 77949.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 160 хувиар биелүүлсэн байна.

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт дугаар 7. Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Орлогын ангилал	2020 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	48,326.80	77,949.30	(29,622.50)
Нийт орлого ба тусламжийн дйн	48,326.80	77,949.30	(29,622.50)
Татварын орлого	48,326.80	77,384.30	(29,057.50)
Орлогын албан татвар	16,750.00	37,381.10	(20,631.10)
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	16,750.00	37,381.10	(20,631.10)
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	16,750.00	37,381.10	(20,631.10)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	-	-	-
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	-	-	-
Хөрөнгийн албан татвар	26,316.80	33,929.60	(7,612.80)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	2,030.00	(2,030.00)
Бууны албан татвар	4,276.80	4,461.00	(184.20)
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	22,040.00	27,438.60	(5,398.60)
Бусад татвар, төлбөр, хураамж	5,260.00	6,073.60	(813.60)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,725.00	3,275.30	449.70
Улсын тэмдэгтийн хураамж	1,960.00	931.50	1,028.50
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	700.00	1,062.60	(362.60)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,065.00	1,281.20	(216.20)
Газрын төлбөр		629.80	(629.80)
Газрын төлбөр	-	629.80	(629.80)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,535.00	2,168.50	(633.50)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	535.00	790.00	(255.00)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,000.00	1,378.50	(378.50)
Татварын бус орлого	-	565.00	(565.00)
Нийтлэг татварын бус орлого	-	565.00	(565.00)
Торгуулийн орлого		565.00	(565.00)

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2307367.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2307367.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 151678.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 4000.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 67678.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 80000 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2307367.0 мянган 1552490.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 137839.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 36847.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 69024.6 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого, 9190.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2270074.9 мянган төгрөгийн санхүүжилтийн олгож, 37292.1 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлого тасарсан байна.

Хүснэгт №8. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			Гүйцэтгэл		Зөрүү	Тайлбар	
		Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого			
1	ЗДТГ	350,882.6	605.0	351,487.6	350,474.5	605.0	351,079.5	(408.1)	санхүүжилт дутуу авсан
2	ИТХ	70,223.8		70,223.8	70,223.8		70,223.8	-	

/мянган төгрөг/

Баянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Сум хөгжүүлэх сан	9,190.2	70,809.8	80,000.0	9,190.2	36,919.1	46,109.3	(33,890.7)	Санхүүжилтийн төлөвлөгөө биелээгүй
4	ОНХС	71,678.2		71,678.2	71,678.2		71,678.2	-	
	ОНБ-дын дүн	501,974.8	71,414.8	573,389.6	501,566.7	37,524.1	539,090.8	(34,298.8)	-
5	ЕБСургууль	942,612.4	5,800.0	948,412.4	942,612.4	5,800.0	948,412.4	-	
6	Хүүхдийн цэцэрлэг	307,167.2		307,167.2	307,167.2		307,167.2	-	
7	Эрүүл мэндийн төв	407,339.3		407,339.3	404,346.0		404,346.0	(2,993.3)	ЭМД сангаас санхүүжилт дутуу
8	Соёлын төв	70,058.5	1,000.0	71,058.5	70,058.5	1,000.0	71,058.5	-	
	ТЗШ дүн	1,727,177.4	6,800.0	1,733,977.4	1,724,184.1	6,800.0	1,730,984.1	(2,993.3)	
	Нийт дүн	2,229,152.2	78,214.8	2,307,367.0	2,225,750.8	44,324.1	2,270,074.9	(37,292.1)	

Үндсэн үйл ажиллагааны орлого 7405.0 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвийн орлогыг биелүүлэн ажилласан байна.

Туслах үйл ажиллагааны орлого 36919.1 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 33890.7 мянган төгрөгөөр буурсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс оруулах орлого биелээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээнд 60488.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 60488.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үлдэгдэл 12064.6 мянган төгрөг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗДТГ нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 69930.0 мянган төгрөг, Засаг даргын захирамжаар ЗДТГ-аас 13014.2 мянган төгрөг, Онцгой байдлын газраас 180,0 мянган төгрөг, ЕБС нь төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 3179.0 мянган төгрөг, ЭМТ нь ЭМГ -аас эм бэлдмэлийн үнэ, сорьц тээврийн ажлын хөлс 8190.2 мянган төгрөг нийт 98510.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт №..... Нэмэлт данс

		/мянган төгрөг/	
		Бусад орлого	Нийт
1	ЗДТГ	87,140.5	87,140.5
3	ЕБСургууль	3,179.4	3,179.4
5	ЭМТ	8,190.2	8,190.2
	Нийт дүн	98,510.1	98,510.1

Нэмэлт дансанд 98510.1 мянган төгрөгийн санхүүжилт тус тус орж батлагдсан арга хэмжээний зардалд зарцуулж. 3480.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 3200.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 9200.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 109.800 мянган төгрөгийн 6 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 66% хэрэгжсэн байна.

Хүснэгт 10 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3.200			1	3.200	
Албан шаардлага	1	9.200	1	9.200			100
Зөвлөмж	6	109.800	6	109.800			100
Нийт		122.200	7	119000	1	3.200	66%

Эх сурвалж: Төрийн аудитын газрын Буянт сумын ТТЗ-ийн 2019 оны тайлан

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 2 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №11. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

Байгууллагын ангилал, нэр	Дүгнэлт					Тайлбар
	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалзсан		
Төсвийн шууд захирагч	ЗДТГ	1				
	ИТХ					түүвэрт хамрагдсан
	Сургууль	1				
	Цэцэрлэг	1				
	ЭМГ	1				
ОНТС	Совлын төв	1				
	СХС					түүвэрт хамрагдсан
	ОНХС					түүвэрт хамрагдсан
Дүн	5					

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-5, нийт 5 дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 23029.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2825.0 мянган төгрөгийн алдааг арилгах төлбөрийн акт, 20204.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

2. Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй болно.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Formatted: Normal, Indent: First line: 0.49", No bullets or numbering, Adjust space between Latin and Asian text, Adjust space between Asian text and

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар дараах 2825.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүлээ. Үүнд:

1. Илрүүлэлт: Тайлант онд хадлангийн бүс нутагт бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэсэн нийт 24 иргэнтэй байгалийн ургамал ашигласны татварын ногдуулалтын төлбөр хураамжийн татварт 2745 боодол пресс өвс хурааж авахаар гэрээ байгуулсан байна.

Тайлант хугацаанд байгалийн ургамал ашигласны татварын төлөвлөгөө нь 5490.3 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1255 боодол пресс өвсийг 5490.0 мянган төгрөгөөр худалдан борлуулж төлөвлөгөөг биелүүлсэн боловч, үлдэгдэл 1490 боодол пресс өвснөөс ачилтын явцад 160 ширхэг пресс өвс задарсан худалдан борлуулах боломжгүй, үлдэгдэл 1330 ширхэг пресс өвсийг цаг тухайн үед нь худалдан борлуулж тайлант оны татварын орлого бүрдүүлээгүй, үлдэгдлийг тайлан баланст бүртгээгүй зөрчил дутагдал илэрлээ.

2. Эрсдэл: Тайлант оны татварын орлого бодитой тайлагнагдахгүй байх, хөрөнгө үрээгдэж алга болох эрсдэл үүсэхээс гадна, Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн Оршин байх батламжид “Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 2.6-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн тэй нийцэхгүй байна.

3. Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад холбогдох мэргэжилтэн, удирдах албан тушаалтнуудаар татварын орлогын ногдуулалтын төлбөрт хураан авсан өвсний үлдэгдэл 1130 боодол пресс өвсний чанар байдлыг шалгаж, худалдан борлуулах үнэ тогтоолгож, яаралтай худалдан борлуулж төсвийг хохиролгүй болгох 1130* 2500/ 2825.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Төвлөрүүлсэн захирагчид 152166.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Буянт сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 105742.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 96967.8 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 8774.9 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 6358.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд төлбөрийн акт, 2416.8 мянган төгрөгийн 10 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 12. ТТЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗДТГ	4	83,930.0	2	83,930.0	2	-
2	ИТХ	-	-				
3	Сургууль	2	4,593.3			2	4,593.3
4	Цэцэрлэг	4	5,553.0	1.0	2,825.0	3	2,728.0
5	ЭМТ	2	1,002.8			2	1,002.8
6	Соёлын төв	5	10,663.6	1.0	10,212.8	4.0	450.8
	Дүн	17	105,742.7	4.0	96,967.8	13	8,774.9

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал, нэр	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
		тоо	дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗДТГ	2	-					2	-
2	ИТХ	0	-						
3	Сургууль	2	4,593.30	1	3,179.3			1	1,414.0
4	Цэцэрлэг	3	2,728.00	1	2,728.0			2	-
5	ЭМТ	2	1,002.80					2	1,002.8
6	Соёлын төв	4	450.80	1	450.8			3	-
Дүн		13	8774.9	3	6358.1	0	0	10	2416.8

Эх сурвалж: Төрийн аудитын газрын 2020 оны санхүүгийн аудитын тайлан

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын хугацаанд Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдэж байгаа тул дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал нь аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа Шаргуугийн услалтын системийн толгойн барилгын ажил, ковид өвчин гарсантай холбоотой сумын төсөвт байгууллагын төрийн албан хаагчдаас суутган авсан нэг өдрийн цалингийн хандивын 2850.0 мянган төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй, ямар зардал санхүүжүүлсэн нь тодорхой бус байгааг авч үзэхийг уламжилж холбогдох баримт материалыг хүргүүлэв.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.1 . ОНХС-ын авлагын бүртгэлтэй холбоотой асуудал

1.1.1. Илрүүлэлт: 2014 онд сумын Засаг даргын захирамжаар жишиг хороололд айл өрхүүдэд сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх зээлийн гэрээгээр 10000.0 мянган төгрөгийн жигд хашаа барьж айл өрхүүдэд хүлээлгэн өгсөн боловч 6204.3 төгрөгийн авлага одоо болтол барагдаагүй байна.

Тайлант оны санхүүгийн тайланд хашааны авлага 9474.3 мянган төгрөгөөс 3270.0 мянган төгрөгийн авлага барагдаж эцсийн үлдэгдэл 6204.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажлын хүрээнд шүүхийн байгууллагад хандсан боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр аймгийн эвлэрүүлэн жуулчлах газарт хандахыг зөвлөсөн байна.

Эвлэрүүлэн жуулчлах газартай хамтран 2020.12.25 хүртэл төлбөр тооцоотой иргэдтэй төлбөр барагдуулах гэрээ хийсэн байна.

1.1.2. Эрсдэл: Сангийн хөрөнгө үр дүн буурах, журмын хэрэгжилт хангаагдахгүй байх.

1.1.3 Өгсөн зөвлөмж: Эвлэрүүлэн жуулчлах газартай хамтран 2020.12.25 хүртэл төлбөр тооцоотой иргэдтэй төлбөр барагдуулах гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах. Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх.

1.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

2.1.ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

2.1.1 Илрүүлэлт: Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар малжуулсан 4 айл өрхийн 14000.0 мянган төгрөгийн малыг ууланд очих боломжгүй гэсэн шалтгааны улмаас шилжүүлээгүй байна.

2.1.2 Эрсдэл: Гэрээний үүрэг хариуцлага суларч, малжуулах сангийн эргэц удаашрах эрсдэлтэй

2.1.3 Өгсөн зөвлөмж: Малжуулах төслийн зээлийг гэрээний үүргийн дагуу шаардан дараагийн иргэнд шилжүүлэх, түүнчлэн Засгийн газрын бодлого, чиглэл, зорилтын хүрээнд тус малжуулах сангийн төслийг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

2.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Буянт сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:
2020			ХОА-2021/ЗСТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Буянт сумын Засаг дарга		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Өвсний үлдэгдэл 1330 ширхэг пресс өвсийг цаг тухайн үед нь худалдан борлуулж тайлант оны татварын орлого бүрдүүлээгүй, үлдэгдлийг тайлан баланст бүртгээгүй зөрчил дутагдал илэрлээ.	2825.0	Төлбөрийн акт	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ч.Нэргүй Г. Уртнасан
2	2014 онд сумын Засаг даргын захирамжаар жишиг хороололд айл өрхүүдэд сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх зээлийн гэрээгээр 10000.0 мянган төгрөгийн жигд хашаа барьж айл өрхүүдэд хүлээлгэн өгсөн боловч	6204.0	Зөвлөмж	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ч.Нэргүй Г. Уртнасан

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	6204.3 төгрөгийн авлага одоо болтол барагдаагүй байна.				
3	Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар малжуулсан 4 айл өрхийн 14000.0 мянган төгрөгийн малыг ууланд очих боломжгүй гэсэн шалтгааны улмаас шилжүүлээгүй байна.	14000.0	Зөвлөмж	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ч.Нэргүй Г. Уртнасан
	Дүн	23029.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР